



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/373

Хэрлэн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11 дэх заалтууд, Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төвлөрлийг сааруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг хавсралт дахь бүрэлдэхүүнээр томилсугай.

2. Ажлын хэсэг чиг үүргийн шинжилгээ хийх төлөвлөгөө боловсруулан батлуулж бэлтгэл ажлыг хангах, шинжилгээний төрөл болон арга зүйг сонгож, холбогдох талуудын оролцоог ханган ажиллах ба үр дүнг заасан хугацаа (3 сар)-нд багтаан тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА